# 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж буй “Эрүүгийн хууль”-д “Авлигын гэмт хэрэг”-ийг хуульчилсан байдал

2018.03.07

# ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЗОРИЛГО

**ЗОРИЛГО 5**

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХӨНДӨГДСӨН ЭРХИЙГ СЭРГЭЭХ

**ЗОРИЛГО 1**

ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ, ҮНЭТ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХ

**ЗОРИЛГО 4**

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ГЭМТ ХЭРЭГТНИЙГ ЦЭЭРЛҮҮЛЭХ




**ЗОРИЛГО 3**

ХҮН ТӨРӨЛХТӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ГЭМТ ХАЛДЛАГААС ХАМГААЛАХ

**ЗОРИЛГО 2**

ХУУЛИАР ХАМГААЛАГДСАН НИЙТЛЭГ АШИГ СОНИРХОЛ

# ЯЛЫН ТӨРӨЛ

- ТОРГОХ
- НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ
- ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ
- ХОРИХ

***Үндсэн ялаар хэрэглэнэ.***

- ЭРХ ХАСАХ- ***нэмэгдэл ялаар хэрэглэнэ.***



# ЯЛЫН БОДЛОГО

- ЭРХ ЧӨЛӨӨГ ХЯЗГААРЛАХ ЯЛ ҮНДСЭН ЗОРИЛГОДОО НИЙЦЭХГҮЙ, ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙГАА УЧИР “БАРИВЧЛАХ” ЯЛЫГ ЭХ-ИАС ХАССАН
- ХОРИХ ЯЛЫН НЭЭЛТТЭЙ ХААЛТТАЙ ДЭГЛЭМД ШИЛЖИЖ, ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛЫГ НЭМЭГДҮҮЛСЭН
- ТЭНСЭХ ЗААЛТЫГ ШИНЭ АГУУЛГААР ТУСГАСАН
- ГЭМ БУРУУГИЙН САНААТАЙ БОЛОН БОЛГООМЖГҮЙ, ЭДГЭЭРИЙН ДАВХАРДСАН ХЭЛБЭРИЙГ ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТУСГАЙ АНГИЙН ЗОХИХ ЗҮЙЛ, ХЭСЭГТ ШУУД, ТОДОРХОЙ ЗААЖ ӨГӨХ ЗАМААР ХУУЛЬЧИЛСАН

- ОНЦ АЮУЛТАЙ ГЭМТ ХЭРЭГТЭН, УРЬД ЯЛ ШИЙТГЭГДСЭН, ДАВТАН ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ГЭСЭН ОЙЛГОЛТЫГ ХАССАН

- ЦААЗААР АВАХ ЗААЛТЫГ ХАССАН. ҮҮНИЙ ОРОНД БҮХ НАСААР ХОРИХ ЯЛЫГ ХУУЛЬЧИЛЖ ӨГСӨН

- ЭХТА-Д ЯЛЫГ СОНГОХ, ДЭЭД БОЛОН ДООД ХЭМЖЭЭГ ХАРЬЦАНГУЙ БОЛОМЖТОЙ ХЭМЖЭЭГЭЭР ХУУЛЬЧИЛЖ ӨГСӨН

- ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ХҮН ГЭМ БУРУУГАА ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧРУУЛСАН ХОХИРЛОО НӨХӨН ТӨЛЖ ХОР УРШГИЙГ АРИЛГАСАН, ЭСХҮЛ ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧРУУЛСАН ХОХИРЛОО НӨХӨН ТӨЛӨХӨӨ ИЛЭРХИЙЛСЭН БОЛ ЯЛЫГ ОНОГДУУЛАХГҮЙГЭЭР ТЭНСЭХ ЗААЛТЫГ ХУУЛЬД НЬ ТУСГАСАН

# ШИНЭ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГ



СОЁЛЫН ӨВИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ



МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГ



АВИЛГА АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРЭГ



ЭДИЙН ЗАСГИЙН, КИБЕР ГЭМТ ХЭРЭГ



ХҮҮХДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ




ХАР ТАМХИ, ХҮНИЙ НАЙМААНЫ ГЭМТ ХЭРЭГ

# ХУУЛИАР ХҮЛЭЭЛГЭСЭН ЧИГ ҮҮРЭГ

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН 6.1 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН 2 ДАХЬ ХЭСЭГТ ЗААСНЫ ДАГУУ ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 22 ДУГААР БҮЛГИЙН 11 ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГ, ӨӨРСДИЙН ИЛРҮҮЛСЭН МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГТ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙНА.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН 2017 ОНЫ А-67 ДУГААР ТУШААЛААР БАТЛАГДСАН ‘’ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ШАЛГАХ, ХЯНАЛТЫН ХАРЬЯАЛАЛ ТОГТООХ’’ АРГАЧИЛСАН ЗААВРЫН ДАГУУ ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧИД ХОЛБОГДОХ ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ, ЭРҮҮГИЙН ХЭРЭГТ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙНА.

## ХОРИН ХОЁРДУГААР БҮЛЭГ
## АВЛИГЫН ГЭМТ ХЭРЭГ /2015/

- 22.1 дүгээр зүйл.Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах
- 22.3 дугаар зүйл.Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах
- 22.4 дүгээр зүйл.Хахууль авах
- 22.5 дугаар зүйл.Хахууль өгөх
- 22.6 дугаар зүйл.Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах
- 22.7 дугаар зүйл.Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх
- 22.8 дугаар зүйл.Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах
- 22.9 дүгээр зүйл.Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах
- 22.10 дугаар зүйл.Үндэслэлгүйгээр хөрөнгөжих
- 22.11 дүгээр зүйл.Дураараа аашлах
- 22.12 дугаар зүйл.Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах

## ХОРИН НАЙМДУГААР БҮЛЭГ
## АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРЭГ /2002/

- 263 дугаар зүйл. Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах
- 264 дүгээр зүйл. Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх
- 265 дугаар зүйл. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах
- 266 дугаар зүйл. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх
- 267 дугаар зүйл. Албан тушаалтны нэр барих
- 268 дугаар зүйл. Хээл хахууль авах
- 269 дүгээр зүйл. Хээл хахууль өгөх
- 270 дугаар зүйл. Хээл хахууль зуучлах
- $270^{1}$ дүгээр зүйл.Хууль бусаар хөрөнгөжих
- 271 дүгээр зүйл. Албан тушаалтан хуурамч баримт бичиг үйлдэх
- 272 дугаар зүйл. Албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандах
- 273 дугаар зүйл. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах

# 22.1 дүгээр зүйл.Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах /1 дэх хэсэг/



# 22.1 дүгээр зүйл.Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах /2 дахь хэсэг/

**Нийтийн албан тушаалтан**

- албан үүрэг,
- бүрэн эрх
- албан тушаалын байдлаа

урвуулан ашиглаж

*2.5.4.1 тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг “их хэмжээ” гэнэ.*

**Их хэмжээний хохирол учруулсан бол**

*5.3.3.Энэ хуульд заасан нэг нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байна.*

- нийтийн албанд томилогдох эрхийг хоёр /2/ жилээс таван /5/ жил хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгж /5400-27000/-тэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;
- эсхүл нэг жилээс таван /1-5/ жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах,
- эсхүл нэг жилээс таван /1-5/ жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

# *22.1 дүгээр зүйл. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах /3 дахь хэсэг/*

**Улс төрд нөлөө бүхий этгээд үйлдсэн бол**

албан үүрэг,

бүрэн эрх,

албан тушаалын байдлаа

урвуулан ашиглаж,

зориуд хэрэгжүүлэхгүй байж

өөртөө

бусдад

**давуу байдал бий болгосон**

Их хэмжээний хохирол учруулсан бол

**нийтийн албанд томилогдох эрхийг таван /5/ жилээс найман /8/ жил хүртэл хугацаагаар хасаж арван мянган нэгжээс дөчин мянган нэгж /10000-40000/-тэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;**

**хоёр жилээс найман жил /2-8/ хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.**

# ХУУЛИЙН ТАЙЛБАР

“Улс төрд нөлөө бүхий этгээд” гэж Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, дэд сайд, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргыг ойлгоно. НБНБХАСЗХАСЗТХууль.20 зүйл

Нийтийн албан тушаалтан **гэдгийг Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд хуульчлагдснаар ойлгоно.**

Албан үүрэг, бүрэн эрх гэдгийг Улсын дээд шүүхийн 2009 оны 23 дугаар тогтоолоор баталсан тайлбарт заасны дагуу ‘’*Сонгууль болон томилолтын албан тушаалтанд хууль тогтоомжоор олгогодсон бүрэн эрх, үндсэн чиг үүргийн нэгдэл*’’ гэж ойлгоно.

Албан тушаалын байдал гэдгийг мөн тайлбарт заасны дагуу ‘’*Албан тушаалтны хэрэгжүүлж байгаа эрх, үүрэгт хамааралгүй боловч тухайн албан тушаалтай холбоотой нэр хүнд, нөлөө*’’-г хэлнэ.

Ноцтой хохирол гэдгийг Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт ‘’Хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эдийн засгийн ач холбогдол бүхий эд хөрөнгийн эрхэд хохирол учирсныг ойлгоно’’ гэж тодорхойлсон

# 22.3 дугаар зүйл.Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах /1 дэх хэсэг/




*Энэ хуульд заасан “**олон улсын байгууллагын албан тушаалтан**” гэж олон улсын, Засгийн газар хоорондын олон улсын байгууллагын ажилтан, тухайн байгууллагыг төлөөлөх, тухайн байгууллагын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах эрх бүхий, тухайн байгууллагаас томилогдсон хүнийг ойлгоно.*

# 22.4 дүгээр зүйл.Хахууль авах /1 дэх хэсэг/

***Хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс***

***албаны чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд***

***эсхүл хэрэгжүүлэхийн төлд***

***шууд***

***эсхүл бусдаар дамжуулан***

**Хахууль өгөхийг**

***шаардсан***

***авсан***

***нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жилээс таван /2-5/ жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээ /2700-14000/-ний төгрөгөөр торгох,;***

***эсхүл зургаан сараас гурван жил хүртэл /6 сар-3 жил/ хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах.***

***эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.***

Субьектийн хувьд нээлттэй, хувийн хэвшил дэх хээл хахууль авах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин бүрдсэн. Банкны хууль тогтоомж зөрчих 156 дугаар зүйл.

# 22.4 дүгээр зүйл.Хахууль авах /2 дахь хэсэг/



# 22.4 дүгээр зүйл.Хахууль авах /3 дахь хэсэг/



# 22.4 дүгээр зүйл.Хахууль авах /4 дэх хэсэг/

*Нийтийн албан тушаалтан*

*Хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс*

*албаны чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд*

*эсхүл хэрэгжүүлэхийн тулд*

*эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийсэн*

*эсхүл хийхийн тулд*

*шууд*

*эсхүл бусдаар дамжуулан*

**Хахууль өгөхийг**

*Шаардсан бол*

*Авсан бол*

*нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жилээс таван /2-5/ жил хүртэл хугацаагаар хасаж арван мянган нэгжээс дөчин мянган нэгж /10000-40000/-тэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох*

*эсхүл хоёр жилээс найман жил /2-8 жил/ хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.*

# 22.4 дүгээр зүйл.Хахууль авах /5 дахь хэсэг/



# 22.4 дүгээр зүйл.Хахууль авах /6 дахь хэсэг/

*Улс төрд нөлөө бүхий этгээд*

*Зохион байгуулалтт ай гэмт бүлэг*

*Хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс*

*албаны чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд*

*эсхүл хэрэгжүүлэхийн тулд*

*эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийсэн*

*эсхүл хийхийн тулд*

*шууд*

*эсхүл бусдаар дамжуулан*

**Хахууль өгөхийг**

*шаардсан*

*авсан*

**Хясан боогдуулах замаар үйлдсэн бол**

***Таван жилээс арван хоёр жил /5-12/ хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.***

# 22.5 дугаар зүйл.Хахууль өгөх /1 дүгээр хэсэг/

**Зорилго**

- Өөртөө, бусдад давуу байдал бий болгох

**хэнд**

- хууль, захиргааны хэм хэмжээний акт, хэлцлээр үүрэг хүлээсэн хүн, эсхүл нийтийн албан тушаалтанд

- албаны чиг үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдалтай нь холбогдуулан

**Хахууль**

- эд зүйл өгсөн,
- эдийн бус баялаг,
- тэдгээрийг өмчлөх эрхийг шилжүүлсэн,
- төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлсэн,
- эсхүл эдгээрийг амласан,
- санал болгосон бол

- нийтийн албанд томилогдох эрхийг хоёр /2/ жил хүртэл хугацаагаар хасаж дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээ /450-14000/-ний төгрөгөөр торгох,
- эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаа /1 сар-3 жил/-аар зорчих эрхийг хязгаарлах,
- эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаа /1 сар-3 жил/-аар хорих ял шийтгэнэ.

# 22.5 дугаар зүйл.Хахууль өгөх /2 дахь хэсэг/

*нийтийн албан тушаалтан* ↔ *зохион байгуулалттай гэмт бүлэг*

**Зорилго**

- Өөртөө, бусдад давуу байдал бий болгох

**хэнд**

- хууль, захиргааны хэм хэмжээний акт, хэлцлээр үүрэг хүлээсэн хүн, эсхүл нийтийн албан тушаалтанд

- албаны чиг үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдалтай нь холбогдуулан

**Хахууль**

- эд зүйл өгсөн,
- эдийн бус баялаг,
- тэдгээрийг өмчлөх эрхийг шилжүүлсэн,
- төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлсэн,
- эсхүл эдгээрийг амласан,
- санал болгосон бол

- **Нийтийн албанд томилогдох эрхийг эрхийг хоёр жилээс таван жил /2-5/ хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгж /5400-27000/-тэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,**
- **эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаа /1-5/-аар зорчих эрхийг хязгаарлах,**
- **эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаа /1-5/-аар хорих ял шийтгэнэ.**

# 22.5 дугаар зүйл.Хахууль өгөх /3 дахь хэсэг/

**Зорилго**

- Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс үйлдсэн

**хэнд**

- хууль, захиргааны хэм хэмжээний акт, хэлцлээр үүрэг хүлээсэн хүн, эсхүл нийтийн албан тушаалтанд

- албаны чиг үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдалтай нь холбогдуулан

хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө

**Хахууль**

- эд зүйл өгсөн,
- эдийн бус баялаг,
- тэдгээрийг өмчлөх эрхийг шилжүүлсэн,
- төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлсэн,
- эсхүл эдгээрийг амласан,
- санал болгосон бол

- хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээ /120000-400000/-ний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

# Хээл хахууль өгөх , зуучлах гэмт үйлдлийн талаар

- Тайлбар: -Хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж хахууль өгч, нийтийн албан тушаалтны хуулийн дагуу албаны чиг үүргээ гүйцэтгэж үзүүлэх төрийн үйлчилгээг авсан хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол түүний авсан төрийн үйлчилгээг хэвээр үлдээж ялаас чөлөөлнө.
- Зуучлагч бол  тухайн гэмт үйлдлийнхээ хамтран оролцогчоор хариуцлага хүлээлгэнэ.

# 22.6 дугаар зүйл.Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах
# /1 дэх хэсэг/

Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан

хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс

албан үүрэгтэйгээ холбоотой аливаа үйлдэл хийх зорилгоор

шууд, эсхүл бусдаар дамжуулан

хахууль өгөхийг шаардсан

хахууль авсан,

эсхүл хахууль өгөх саналыг хүлээн зөвшөөрсөн

- **таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаа /5-12/-аар хорих ял шийтгэнэ.**

# 22.6 дугаар зүйл.Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах /2 дахь хэсэг/

Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтанд

албаны чиг үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдал, олон улсын үйл ажиллагаатай нь холбогдуулан

давуу байдал олж авах, эсхүл давуу байдлаа хадгалах зорилгоор

эдийн, эдийн бус баялаг, тэдгээрийг өмчлөх эрхийг шилжүүлсэн

төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлсэн,

эсхүл төлбөргүй, хөнгөлөлттэй үйлчилгээ амласан,

эсхүл төлбөргүй, хөнгөлөлттэй үйлчилгээ санал болгосон

- нийтийн албанд томилогдох эрхийг гурван жил /3/ хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгж /5400-27000/-тэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,
- эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаа /1-5/-аар зорчих эрхийг хязгаарлах,
- эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаа /1-5/-аар хорих ял шийтгэнэ.

# 22.7 дугаар зүйл.Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх /1 дэх хэсэг/




- нийтийн албанд томилогдох эрхийг гурван жил /3/ хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгж /5400-27000/-тэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,
- эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаа /1-5/-аар зорчих эрхийг хязгаарлах,
- эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаа /1-5/-аар хорих ял шийтгэнэ.

# 22.8 дугаар зүйл.Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах /1 дэх хэсэг/




- нийтийн албанд томилогдох эрхийг гурван жил хүртэл хугацаа /3/-аар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгж /5400-27000/-тэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,
- эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаа /1-5/-аар зорчих эрхийг хязгаарлах,
- эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаа /1-5/-аар хорих ял шийтгэнэ.

# 22.8 дугаар зүйл.Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах /2 дахь хэсэг/

Төсөв захирагч төрийн өмч, төсвийн хөрөнгийг:

1.1.зориулалтын бусаар зарцуулсан;

1.2.зах зээлийн дунджаас дээгүүр үнээр “бараа, ажил, үйлчилгээ”худалдан авсан;

1.3.нөөцлөх нэрээр хэрэгцээнээс илүү хэмжээгээр бараа, бүтээгдэхүүн худалдан авч, мөнгөний эргэлтийг саатуулсан;

1.4.зохиомол хомсдол бий болгох замаар бараа, бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх үнийг зориудаар өсгөсөн;

1.5.төрийн өмчийн, төсөвт байгууллагын эд хөрөнгийг зах зээлийн дунджаас доогуур үнээр борлуулсан;

1.6.улсын төсвийн, өөрийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралтад шаардлага хангаагүй бараа, бүтээгдэхүүн ашиглах замаар төсөвт өртгийг бүрдүүлж хөрөнгө завшсанаас

ИХ ХЭМЖЭЭНИЙ ХОХИРОЛ УЧРУУЛСАН БОЛ

**хоёр жилээс найман жил хүртэл хугацаа /2-8/-аар хорих ял шийтгэнэ.**

# 22.9 дүгээр зүйл.Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах /1 дэх хэсэг/

**1.Нийтийн албан тушаалтан төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг**

1.1.зориулалтын бусаар зарцуулсан;

1.2.зах зээлийн дунджаас дээгүүр үнээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан;

1.3.зохиомол хомсдол бий болгох замаар бараа, бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх үнийг зориудаар өсгөсөн;

1.4.төрийн өмчийн, төсөвт байгууллагын эд хөрөнгийг зах зээлийн дунджаас доогуур үнээр борлуулсны улмаас

**<u>үлэмж хэмжээний хохирол учирсан</u>**

нийтийн албанд ажиллах, эсхүл сонгогдох эрхийг хоёр жилээс таван жил /2-5/ хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгж /5400-27000/-тэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,

**2.5.4.2.“үлэмж хэмжээний хохирол” гэж арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг;**

эсхүл нэг жилээс таван /1-5/ жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах,

эсхүл нэг жилээс таван /1-5/ жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

:

# 22.9 дүгээр зүйл.Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах /2 дахь хэсэг/



# 22.10 дугаар зүйл.Үндэслэлгүйгээр хөрөнгөжих /1 дэх хэсэг/

- өөрийн хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь хууль ёсны болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй бол

1.Нийтийн албан тушаалтан

Ял

- үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж, нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох

- эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах,
- эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Ял

# 22.10 дугаар зүйл.Үндэслэлгүйгээр хөрөнгөжих /2 дахь хэсэг/

- өөрийн хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь хууль ёсны болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй бол

**2.Улс төрд нөлөө бүхий этгээд**

**Ял**

- үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж, нийтийн албанд томилогдох, эсхүл сонгогдох эрхийг хоёр жилээс таван жил /2-5/ хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгж /5400-27000/-тэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,

эсхүл нэг жилээс таван жил /1-5/ хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах,

эсхүл нэг жилээс таван жил /1-5/ хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ

**Ял**

# 22.11 дүгээр зүйл.Дураараа аашлах

**1.Нийтийн албан тушаалтан**

*өөрт олгогдоогүй албан тушаалын бүрэн эрхийг бусдын нэрийн өмнөөс хэрэгжүүлсэн*

*өөрт олгогдоогүй албан тушаалын бүрэн эрхийг ашигласны улмаас*

*бусдын эрх ашигт ноцтой хохирол учирсан*
*/2.5.3* Энэ хуульд заасан "ноцтой хохирол" гэж хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эдийн засгийн ач холбогдол бүхий эд хөрөнгийн эрхэд хохирол учирсныг ойлгоно./

нийтийн албанд томилогдох эрхийг хоёр /2/ жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгж /2700-14000/-тэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, .

эсхүл зургаан сараас гурван жил /6 сар-3 жил/ хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах

эсхүл зургаан сараас гурван жил хүртэл /6 сар-3 жил/ хугацаагаар хорих ял шийтгэнэ.

# 22.12 дугаар зүйл.Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах

***Хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан***

- *Хувьдаа давуу байдал тогтоох*
- *бусдад давуу байдал тогтоох*
- *ашиг хонжоо олох зорилгоор*

***хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт, хэлцэл, дүрмээр олгогдсон албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас***

*үлэмж хэмжээний хохирол учруулсан /2.5.4.2."үлэмж хэмжээний хохирол" гэж арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгоно./*

**Ял**

- *хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээ /2700-14000/-ний төгрөгөөр торгох,*
- *эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаа /6 сараас 3 жил/-аар зорчих эрхийг хязгаарлах,*
- *бол эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаа /6 сараас 3 жил/-аар хорих ял шийтгэнэ*

- 2.5 дугаар зүйл. **Гэмт хэргийн хохирол, хор уршиг**
- 1.Энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.
- 2.Энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдэж хохирол учруулсны улмаас үүссэн үр дагаврыг гэмт хэргийн хор уршигт тооцно.
- 3.Энэ хуульд заасан “ноцтой хохирол” гэж хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эдийн засгийн ач холбогдол бүхий эд хөрөнгийн эрхэд хохирол учирсныг ойлгоно.
- 4.Энэ хуульд заасан дараах хохирлын хэмжээг дор дурдсанаар ойлгоно.
- 4.1.“их хэмжээний хохирол” гэж тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг; /50,0 сая /
- 4.2.”үлэмж хэмжээний хохирол” гэж арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг; /10,0 сая /
- 4.3.”бага хэмжээний хохирол” гэж гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс доош хэмжээг. /300,000 төгрөг /
- 5.Шүүх гэмт хэргийн хохирол, хор уршгийг тодорхойлж, бодит хохирлыг нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгахад гарах зардлын мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх хэмжээг тогтооно.

# АНХААРАН СОНССОН ТА БҮХЭНД БАЯРЛАЛАА